

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Байгууллагын даргын 01/09-07 дугаар удирдамжийн дагуу Өмнөд бүс дэх газрын 2022 оны эхний гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн хүрээнд батлан гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, түүний үр дүнд үндэслэн дараах 3 чиглэлээр зөвлөмж хүргүүлж байна.

Нэг. Санхүүгийн аудитын чиглэлээр:

1.1.Төсвийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтад QR бар кодтой цахим төлбөрийн баримтын нэхэмжлэгчийн нэр зөрөхгүй байх;

1.2.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасны дагуу санхүүгийн үйл ажиллагаанд удирдлагаас тавих хяналтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмыг баримтлан ажиллах;

1.3.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасны дагуу бараа материалын тайланг анхан шатны маягтын дагуу үнэн зөв, бүрэн хөтлөх, хяналт шалгалтын төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслэн анхан шатны баримтаар тухай бүр гүйлгээ хийж бүртгэлд тусгах, зарцуулалтын хэтрэлт, хэмнэлтийг тооцож ажиллах;

1.4.Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоол "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай"-ыг хэрэгжүүлэн ажиллах.

Хоёр. Нийцлийн аудитын чиглэлээр:

2.1.Захирамжлалын баримт бичгийн үндэслэл хэсэгт эрх зүйн актыг зөв үндэслэх, зүйл заалт, батлагдсан огноог бүтэн бичих, хууль, журмын үйлчлэх хүрээ хязгаар, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсэхийг тухай бүр нягтлах;

2.2.Захирамжлалын баримт бичгийн захирамжлах хэсэгт уг баримт бичгийг заалт бүр нь тодорхой хэм хэмжээ тогтоосон байх, агуулга нь учир зүйн дэс дараалалтай байх, бичвэрийн агуулга монгол хэлний өгүүлбэр зүй, найруулга, зөв бичих дүрэмд нийцүүлэх;

2.3.Тушаал, шийдвэр батлан гаргахдаа тавигдах шаардлагыг бүрэн хангаж, холбогдох хавсралт болон нотлох баримтыг бүрдүүлж төвийн Санхүүгийн хэлтсийн дарга, Захиргаа, удирдлагын газрын хуулийн ахлах мэргэжилтнээс тухай бүр зөвлөгөө, мэдээлэл авч ажиллах.

Гурав. Бусад:

3.1.Хариуцсан албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, богино болон дунд хугацааны сургалтад хамруулах, туршлага солилцох, харилцан суралцах, хувь хүн өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхаарч ажиллах зэрэг болно.

--oo0oo—